

ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН 2007 ОНЫ САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2006 оны байдлаар манай улсын даатгалын салбарт 22 компани даатгалын үйл ажиллагаа эрхэлж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан даатгалын гэрээний дагуу даатгуулагчдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хариуцлагыг тохиолдож болзошгүй эрсдэлүүдээс хамгаалж байсан бол 2007 онд 7 компани даатгалын үйл ажиллагаагаа зогсоож, тайлант оны эцэст даатгалын зах зээлд 15 даатгагч үлдсэн (Зураг-1). Даатгалын зах зээлд оролцогч даатгагчдын тоо ийнхүү буурсан гол шалтгаан нь Даатгалын тухай хуулийн 22.1 дахь заалтыг хэрэгжүүлэх шаардлагыг тавьж, даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 500 сая төгрөг болгож нэмэгдүүлсэнтэй холбоотой байв.

Зураг - 1




2007 онд “Чин үйлс даатгал”, “Стюардесса сара даатгал”, “Эрэл даатгал”, “Транс иншуранс даатгал”, “Капитал даатгал”, “Монголын үндэсний даатгал”, “Элсиэс монгол даатгал” ХХК-нууд Даатгалын тухай хуулийн 22.1, 25.1 дахь заалтуудыг биелүүлээгүй, компанийн дүрмийн санг Хорооноос олгосон боломжит хугацаанд хуулинд заасан хэмжээнд хүргэж нэмэгдүүлээгүй, даатгалын нөөц санг шаардлагын дагуу бүрдүүлээгүй тул эдгээр компанийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон.

Тайлант онд даатгалын компаниудад давхардсан тоогоор сайн дурын ердийн даатгалын 220 хэлбэрээр тусгай зөвшөөрөл олгосноос 45.9 хувь буюу 101 нь эд хөрөнгийн, 37.3 хувь буюу 82 нь хариуцлагын, 14.5 хувь буюу 32 нь амь нас, эрүүл мэндийн, 2.3 хувь буюу 5 нь санхүүгийн даатгалын төрөлд хамаарагдаж байлаа (Зураг-2). Эдгээр даатгалын хэлбэрүүдээс “Монгол даатгал” ХХК даатгалын 32 хэлбэрээр тусгай зөвшөөрөл авч

даатгалын салбарын хэмжээнд тэргүүлсэн бол “Ганзам даатгал” ХХК даатгалын 7 хэлбэр буюу хамгийн цөөхөн даатгалын хэлбэрийн тусгай зөвшөөрөл авсан байна.


Зураг – 2




II. ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН ХӨРӨНГӨ

Даатгалын зах зээл дээр сайн дурын ердийн даатгалын үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудын хөрөнгийн нийт хэмжээ 2007 онд 28.4 тэрбум төгрөгт хүрч өнгөрөгч 2006 оныхоос 36.5 хувиар буюу 7.6 тэрбум төгрөгөөр нэмэгдлээ (Зураг-3). Даатгагчдын хөрөнгийн хэмжээний өөрчлөлтийн хандлагыг сүүлийн 5 жилийн байдлаар харахад 2006 оныг эс тооцвол тогтвортой өсч 2.2 дахин нэмэгдсэн нь манай бодоотдын даатгалын салбар өргөжин хөгжиж ирснийг харуулж байна.

Зураг - 3



Даатгалын компаниудын нийт хөрөнгөд эргэлтийн хөрөнгийн эзлэх хувийн жин сүүлийн 5 жилийн байдлаар 80 орчим хувьтай хадгалагдаж, бага зэргийн өсөлт гарсан нь харагдаж байна (Зураг-4).



Даатгагчдын нийт хөрөнгийн дийлэнх хэсгийг бүрдүүлж байгаа эргэлтийн хөрөнгийн бүтцийг сүүлийн 3 жилийн байдлаар харахад мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ хамгийн өндөр буюу дунджаар 67.6 хувь, богино хугацаат хөрөнгө оруулалт дунджаар 12.0 хувь, дансны авлага дунджаар 9.4 хувь, бусад эргэлтийн хөрөнгө дунджаар 11.0 хувь орчим байсан бөгөөд уг хөрөнгийн бүтцэд мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байна (Хүснэгт-1).

Хүснэгт - 1

Эргэлтийн хөрөнгийн бүтэц

Үзүүлэлтүүд	2005		2006		2007	
	Хөрөнгө (сая төгрөг)	эзлэх хувь	Хөрөнгө (сая төгрөг)	эзлэх хувь	Хөрөнгө (сая төгрөг)	эзлэх хувь
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	12 171.1	67.8	12 510.4	70.8	15 600.1	64.3
Богино хугацаат хөрөнгө оруулалт	2 393.7	13.3	1 749.9	9.9	3 065.4	12.6
Дансны авлага	1 812.7	10.1	1 747.0	9.9	1 979.8	8.2
Бусад эргэлтийн хөрөнгө	1 565.7	8.7	1 675.2	9.5	3 625.2	14.9
Эргэлтийн хөрөнгийн дүн	17943.2	100.0	17682.5	100.0	24270.5	100.0


2007 онд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг хөрөнгийн хэмжээгээр жагсаахад “Монгол даатгал” ХХК 11.7 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 41.1 хувийг эзэлж даатгалын салбарыг хөрөнгийн хэмжээгээрээ тэргүүлж байгаа бол “Нийслэл даатгал” ХХК 0.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр нийт зах зээлийн 2.2 хувийг эзэлж байна (Хүснэгт-2).

Даатгалын компаниудын хөрөнгийн хэмжээ

№	Даатгалын компаниудын нэр	Нийт хөрөнгийн дүн (сая төгрөг)	Эзлэх хувь
1	Монгол даатгал	11,671.0	41.1
2	Бодь даатгал	2,542.0	9.0
3	Миг даатгал	1,787.5	6.3
4	Ард даатгал	1,627.0	5.7
5	Прайм женерал даатгал	1,545.8	5.4
6	Түшиг даатгал	1,254.5	4.4
7	Номин даатгал	1,215.4	4.3
8	Улаанбаатар хотын даатгал	1,125.4	4.0
9	УБ даатгал	980.2	3.5
10	Монголд траст холдинг даатгал	842.9	3.0
11	Мөнх даатгал	839.7	3.0
12	Практизал даатгал	826.0	2.9
13	Ганзам даатгал	803.9	2.8
14	Жонон даатгал	694.1	2.4
15	Нийслэл даатгал	622.5	2.2
	ДҮН	28,377.9	100.0

III. ӨР ТӨЛБӨР, ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Даатгалын компаниудын нийт хөрөнгөн дахь эзэшигчдийн өмч, даатгалын учирч болзошгүй хохирлын нөөц сан, өр төлбөрийн харьцааг сүүлийн 3 жилийн байдлаар дүгнэж харахад даатгалын нөөц сангийн хувь хэмжээ тогтвортой нэмэгдэж ирсэн байна (Зураг-5).



2007 оны эцсийн байдлаар даатгалын учирч болзошгүй хохирлын нөөц сангийн хэмжээ 17.8 тэрбум төгрөгт хүрч 2006 оны жилийн эцэстэй харьцуулахад 5.6 тэрбум төгрөгөөр буюу 45.9 хувиар өслөө. Даатгалын салбарын хэмжээгээр нөөцийн сангийн хэмжээний энэхүү өндөр өсөлтийг “Монгол даатгал” ХХК-ын нөөцийн сан 2.9 тэрбум төгрөг буюу 45.9 хувиар өссөнөөр тайлбарлаж болохоор байна.

Тайлант хугацаанд даатгалын салбарын хэмжээгээр 2006 оныхоос хуримтлагдсан алдагдал 303.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад алдагдлын хэмжээ 594.2 сая төгрөгөөр буюу 2.9 дахин буурсан үзүүлэлт гарлаа. Энэ нь 2007 оны сүүлийн хагас жилээс эхлэн нөөц санг байгуулах 8-тын систем нэвтрүүлсний эерэг үр дүн гарч эхэлж байгаатай шууд холбоотой гэж үзэж байна.

ҮҮ. ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН АШИГТ АЖИЛЛАГАА

Тайлант хугацаанд даатгалын салбар 16.8 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого олсноос 4.5 тэрбум төгрөг буюу 27.0 хувийг давхар даатгалын хураамжинд, 0.1 тэрбум төгрөгийг буюу 0.5 хувийг буцаасан даатгалын хураамжинд өгч, 12.2 тэрбум төгрөгийн даатгалын цэвэр хураамжийн орлогыг төвлөрүүлсэн. Энэхүү даатгалын цэвэр хураамжийн 57.3 хувь буюу 7.0 тэрбум төгрөгийг орлогод тооцсон хураамжаар тооцож, үлдэх 42.7 хувь буюу 5.2 тэрбум төгрөгийг орлогод тооцоогүй хураамжийн нөөцөд бүртгэсэн байна.

2007 онд “Түшиг даатгал”, “Мөнх даатгал”, “Нийслэл даатгал” ХХК-ууд 13.9-87.3 сая төгрөгийн тайлант хугацааны алдагдалтай ажилласан бол даатгалын салбарын хэмжээгээр 633.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. Энэ онд “Бодь даатгал” ХХК 276.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, салбарын хэмжээнд олсон ашгийн 43.7 хувийг эзэлж байгаа бол “Түшиг даатгал” ХХК 87.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна (Хүснэгт-

3). Харин нийт хөрөнгө, даатгалын хураамжийн орлогын хэмжээгээрээ даатгалын зах зээлийг тэргүүлдэг “Монгол даатгал” ХХК 2007 онд 38.9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь нийт системийн хэмжээний ашгийн дөнгөж 6.1 хувийг эзэлж байна.


Хүснэгт – 3

Даатгалын компанийн цэвэр ашиг (алдагдал)

№	Даатгалын компаниудын нэр	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) (мянган төгрөг)	Эзлэх хувь
1	Бодь даатгал	276,587.1	43.7
2	Номин даатгал	105,731.5	16.7
3	Ард даатгал	84,512.9	13.3
4	Улаанбаатар хотын даатгал	73,197.3	11.6
5	Миг даатгал	63,555.7	10.0
6	Жонон даатгал	45,443.1	7.2
7	Монгол даатгал	38,890.2	6.1
8	УБ даатгал	37,703.3	6.0
9	Ганзам даатгал	29,843.0	4.7
10	Прайм женерал даатгал	23,925.6	3.8
11	Монгол траст холдинг даатгал	18,082.2	2.9
12	Практикал даатгал	208.3	0.0
13	Нийслэл даатгал	(13,948.7)	(2.2)
14	Мөнх даатгал	(62,835.6)	(9.9)
15	Түшиг даатгал	(87,342.2)	(13.8)
	НИЙТ ДҮН	633,553.4	100.0

V. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО

2007 онд даатгалын салбарын хэмжээгээр 16.9 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого олсны 62.2 хувь буюу 10.5 тэрбум төгрөг нь эд хөрөнгийн даатгалын, 27.0 хувь буюу 4.6 тэрбум төгрөг нь хариуцлагын даатгалын, 8.8 хувь буюу 1.5 тэрбум төгрөг нь амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгалын, 2.0 хувь буюу 0.3 тэрбум төгрөг нь санхүүгийн даатгалын хураамжаас орсон орлого байлаа (Зураг-6).



2006 оныхтой харьцуулахад даатгалын хураамжийн орлогын нийт хэмжээ 2007 онд 43.7 хувиар буюу 5.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтийг эд хөрөнгийн даатгалын хураамжийн орлогын 48.2 хувь болон хариуцлагын даатгалын 36.6 хувийн өсөлтөөр тус тус хангажээ (Хүснэгт-4).

Хүснэгт – 4

Даатгалын хураамжийн орлого

Даатгалын ангилал	2006 (сая төг)	2007 (сая төг)	Өсөлт/бууралт		Өсөлтийн хувь
			(сая төг)	хувь	
1. Амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал	1 048.4	1 495.0	446.6	142.6	8.7
2. Эд хөрөнгийн даатгал	8 051.4	10 534.7	2 483.3	130.8	48.2
3. Хариуцлагын даатгал	2 679.3	4 566.4	1 887.1	170.4	36.6
4. Санхүүгийн даатгал		333.0	333.0		6.5
Дүн	11 779.1	16 929.1	5 150.0	143.7	100.0

Даатгалын компаниудыг тайлант онд олсон даатгалын хураамжийн орлогоор нь зэрэгцүүлэхэд “Монгол даатгал” ХХК 6.3 тэрбум төгрөгийн хураамжийн орлого олсон нь

нийт даатгалын салбарын хэмжээнд олсон хураамжийн орлогын 37.0 хувийг, “Ганзам даатгал” ХХК 0.05 тэрбум төгрөгийн хураамжийн орлого олж салбарын хэмжээнд олсон хураамжийн орлогын 0.3 хувийг эзэлсэн дүнтэй байна (Хүснэгт-5).

Хүснэгт - 5

Даатгалын хураамжийн орлого

№	Даатгалын компаниудын нэр	Хураамжийн орлого (сая төг)	Эзлэх хувь
1	Монгол даатгал	6 258.5	37.0
2	Бодь даатгал	4 280.8	25.3
3	Миг даатгал	1 325.8	7.8
4	Прайм женерал даатгал	1 086.1	6.4
5	Номин даатгал	922.0	5.4
6	Ард даатгал	764.0	4.5
7	Практикал даатгал	462.4	2.7
8	Түшиг даатгал	457.5	2.7
9	Улаанбаатар хотын даатгал	411.4	2.4
10	Мөнх даатгал	263.6	1.6
11	Жонон даатгал	241.2	1.4
12	УБ даатгал	176.4	1.0
13	Монгол траст холдинг даатгал	136.3	0.8
14	Нийслэл даатгал	92.5	0.5
15	Ган зам даатгал	50.6	0.3
	ДҮН	16 929.1	100.0

ҮІ. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР


Тайлант хугацаанд даатгалын зах зээл дээр нийт 3.4 тэрбум төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон нь 2006 оныхтой харьцуулахад 21.6 хувиар буюу 0.6 тэрбум төгрөгөөр өслөө. Энэхүү өсөлтөд эд хөрөнгийн даатгалын нөхөн төлбөрийн 37.3 хувийн болон хариуцлагын даатгалын нөхөн төлбөрийн 35.3 хувийн өсөлт тус тус нөлөөлсөн байна (Хүснэгт - 6).

Даатгалын нөхөн төлбөр

Даатгалын ангилал	2006 (сая төг)	2007 (сая төг)	Өсөлт/бууралт		Өсөлтийн хувь
			(сая төг)	хувь	
1. Амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал	375.7	427.2	51.5	113.7	8.6
2. Эд хөрөнгийн даатгал	2047.3	2 270.9	223.6	110.9	37.3
3. Хариуцлагын даатгал	352.9	564.6	211.7	160.0	35.3
4. Санхүүгийн даатгал		112.8	112.8		18.8
Дүн	2 775.9	3 375.5	599.6	121.6	100.0

Даатгалын нөхөн төлбөрийг даатгалын дэд ангиллаар нь авч үзэхэд 2007 онд эд хөрөнгийн даатгалын нөхөн төлбөр 67.3 хувь, хариуцлагын даатгалын нөхөн төлбөр 16.7 хувь, амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгалын нөхөн төлбөр 12.7 хувь, хариуцлагын даатгалын нөхөн төлбөр 3.3 хувийг эзэлж байна. Энэхүү бүтцийг өмнөх онтой харьцуулахад сайн дурын ердийн даатгалын санхүүгийн даатгалын хэлбэр шинээр бий болсонтой холбогдуулан бүтцэд ялимгүй өөрчлөлт гарснаас өөр огцом өөрчлөлтгүй байна. (Зураг -7).

Зураг – 7



Даатгалын компаниудыг 2007 онд олгосон даатгалын нөхөн төлбөрөөр нь зэрэгцүүлэхэд “Монгол даатгал” ХХК 1.8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгож нийт

системийн хэмжээнд олгосон нөхөн төлбөрийн 52.7 хувийг олгосон бол “Ганзам даатгал” ХХК 0.004 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр төлж нийт системийн хэмжээнд олгосон нөхөн төлбөрийн 0.1 хувийн эзэлж байна (Хүснэгт-7).

Хүснэгт - 7

Даатгалын нөхөн төлбөр

№	Даатгалын компаниудын нэр	Нөхөн төлбөр (сая төг)	Эзлэх хувь
1	Монгол даатгал	1 778.3	52.7
2	Номин даатгал	320.2	9.5
3	Миг даатгал	301.8	8.9
4	Ард даатгал	193.9	5.7
5	Бодь даатгал	179.7	5.3
6	Мөнх даатгал	157.4	4.7
7	Прайм женерал даатгал	145.8	4.3
8	Түшиг даатгал	90.6	2.7
9	Практикал даатгал	79.1	2.3
10	Улаанбаатар хотын даатгал	45.4	1.3
11	Жонон даатгал	36.2	1.1
12	УБ даатгал	27.8	0.8
13	Нийслэл даатгал	11.6	0.3
14	Монгол траст холдинг даатгал	4.0	0.1
15	Ганзам даатгал	3.8	0.1
	ДҮН	3 375.5	100.0

VII. ДААТГАЛЫН ХОХИРОЛ НӨХӨЛТИЙН ТҮВШИН

Тайлант онд даатгалын хохирол нөхөлтийн түвшин даатгалын салбарын дүнгээр 19.9 хувь болсон нь 2006 оныхтой харьцуулахад 3.7 пунктээр буурлаа. Хохирол нөхөлтийн түвшинг даатгалын хэлбэрийн дэд ангиллаар авч үзэхэд амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал 28.6 хувь болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 7.2 пунктээр, эд хөрөнгийн даатгал 21.6 хувь болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 3.8 пунктээр, хариуцлагын даатгал 12.4 хувь болж өмнөх оны мөн үеийнхээс 0.8 пунктээр тус тус буурсан байна (Хүснэгт-8).

Даатгалын хохирол нөхөлтийн түвшин

(сая төгрөг)

Даатгалын ангилал	2006			2007		
	Хураамжийн орлого	Нөхөн олговор	Нөхөн олговрын түвшин	Хураамжийн орлого	Нөхөн олговор	Нөхөн олговрын түвшин
Амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал	1 048.4	375.7	35.8	1 495.0	427.2	28.6
Эд хөрөнгийн даатгал	8 051.4	2 047.3	25.4	10 534.7	2 270.9	21.6
Хариуцлагын даатгал	2 679.3	352.9	13.2	4 566.4	564.6	12.4
Санхүүгийн даатгал				333.0	112.8	33.9
Дүн	11 779.1	2 775.9	23.6	16 929.1	3 375.5	19.9

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудын даатгалын нөхөн төлбөр олголтын түвшинг харьцуулж үзэхэд 2007 оны байдлаар “Мөнх даатгал” ХХК-ийн нөхөн төлбөр олголтын түвшин 63.0 хувьд хүрч хамгийн өндөр байсан бол “Ганзам даатгал” ХХК 2.1 хувь болж хамгийн бага түвшинтэй байв (Хүснэгт-9).

Хүснэгт - 9


Даатгалын нөхөн төлбөрийн түвшин

(сая төгрөг)

№	Даатгалын компанийн нэр	2006	2007	Өсөлт/бууралт
1	Монгол даатгал	34.9	28.4	-6.5
2	Түшиг даатгал	27.2	19.8	-7.4
3	Ард даатгал	21.2	25.4	4.2
4	Бодь даатгал	6.3	4.2	-2.1
5	Прайм женерал даатгал	20.5	13.4	-7.1
6	Миг даатгал	7.6	22.8	15.2
7	УБ даатгал	27.1	15.7	-11.4
8	Улаанбаатар хотын даатгал	14.1	11	-3.1
9	Номин даатгал	56	34.7	-21.3
10	Жонон даатгал	16.2	15	-1.2
11	Монгол траст холдинг даатгал	8.9	2.9	-6
12	Практикал даатгал	7.6	17.1	9.5
13	Мөнх даатгал	27.7	59.7	32
14	Нийслэл даатгал	5.5	12.5	7
15	Ган зам даатгал	-	7.5	7.5
	ДҮН	23.6	19.9	-3.7

Даатгалын хураамжийн орлого сүүлийн 7 жилд харьцангуй тогтвортой өндөр өсөлттэй байсан ч нөхөн төлбөр олголтын өсөлт нь даатгалын хураамжийн орлогын өсөлтийн хурдцыг гүйцэхгүй, харьцангуй бага байсан учраас сүүлийн жилүүдэд даатгалын хураамж, нөхөн төлбөрийн өсөлтийн зөрүү ихсэх хандлагатай болсон (Зураг-8).

Зураг - 8



VIII. ДАВХАР ДААТГАЛ

Тайлант онд даатгалын 6 компани нийт 4.5 тэрбум төгрөгийн давхар даатгал хийлгэж, даатгуулагчдыг учирч болзошгүй даатгалын эрсдэлээс хамгаалж давхар даатгуулсан нь өмнөх 2006 онтой харьцуулахад 60.5 хувиар буюу 1.7 тэрбум төгрөгөөр өслөө. Давхар даатгалын хураамжийн хэмжээ ийнхүү өссөн нь “Бодь даатгал” ХХК-ын давхар даатгалын хураамжийн хэмжээ өмнөх оныхоос 30 дахин өссөнтэй холбоотой байна (Хүснэгт-10).

Хүснэгт - 10

Давхар даатгалын хураамж

№	Даатгалын компанийн нэр	2006		2007		Өсөлт/бууралт	
		(сая төг)	эзлэх хувь	(сая төг)	эзлэх хувь	(сая төг)	хувь
1	Монгол даатгал	710.0	25.2	868.1	19.1	158.1	122.3
2	Ард даатгал	51.3	1.8	86.5	1.9	35.2	168.7
3	Бодь даатгал	104.7	3.7	3124.4	68.6	3019.7	30дахин
4	Прайм женерал даатгал	75.8	2.7	45.0	1.0	- 30.8	59.4
5	Номин даатгал	45.7	1.6	21.6	0.4	- 24.1	47.3


6	Практикал даатгал*	1.2	0.0	38.9	0.9	- 1.2	-
7	Миг даатгал**	-	-	369.7	8.1	369.7	-
8	Монголын даатгалын групп***	1803.0	64.1	-	-	- 1803.0	-
9	Монголын үндэсний даатгал***	21.3	0.8	-	-	- 21.3	-
	ДҮН	2812.9	100.0	4554.1	100.0	1702.4	160.5

** - Миг даатгал 2007 онд давхар даатгалын үйл ажиллагаа явуулж эхэлсэн

*** -2006 онд давхар даатгалын үйл ажиллагаа эрхэлж байсан боловч 2007 онд татан буугдсан

2007 оны давхар даатгалын хураамжийг даатгалын дэд ангиллын бүтцээр нь задлан харахад нийт хураамжийн 56.3 хувь буюу 2.5 тэрбум төгрөгийг эд хөрөнгийн даатгалд, 42.7 хувь буюу 1.9 тэрбум төгрөгийг хариуцлагын даатгалд, 1.0 хувь буюу 0.04 тэрбум төгрөгийг амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгалын хураамжинд төлсөн байна (Зураг-9).

Зураг - 9



IX. ДҮГНЭЛТ, САНАЛ

1. Тайлант оноос өмнө даатгалын компаниудын даатгалын хураамжийн орлогын хэмжээ өмнөх оныхоосоо жилд дунджаар 18-24 хувиар өссөн үзүүлэлттэй гарч байсан бол 2007 онд 43.7 хувь болж нэмэгдлээ. Энэ нь даатгалын зах зээл дээр шалгарч үлдсэн 15 даатгалын компани тайлант хугацаанд санхүүгийн болон даатгалын идэвхтэй үйл ажиллагаа явуулж, илүү олон даатгуулагчдыг татаж, гэрээ байгуулан ажиллаж чадсантай холбоотой гэж дүгнэж байна.

Гэвч зарим даатгалын компаниудын хураамжийн орлогын хэмжээ өмнөх онуудынхтай харьцуулахад төдийлэн өсөөгүй, даатгалын хураамжийн бүтэц нь хэвээрээ буюу уламжлалт цөөхөн төрлийн даатгал хийсээр байгаа нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, уламжлалт хэлбэрийн даатгалуудыг урсгалаар хийж, шинээр даатгалын бүтээгдэхүүн гаргаж зах зээлд нэвтрүүлэх талаар идэвх санаачлага гаргаагүй, хангалтгүй ажиллаж байгаа юм. Тухайлбал, “Ганзам даатгал”, “УБ даатгал”, “Монголтраст холдинг даатгал”, “Жонон даатгал”, “УБ хотын даатгал” зэрэг компаниуд даатгалын шинэ бүтээгдэхүүн гаргаж нэвтрүүлээгүй байна.

2. Мөн даатгалын компаниудыг 2007 онд олсон даатгалын хураамжийн хэмжээгээр нь байр эзлүүлж үзэхэд даатгалын нэг томоохон гэрээнээс хамааран тухайн даатгалын компанийн хураамжийн хэмжээ болон даатгалын зах зээлд эзлэх хувийн жин нь нэмэгдэж буурдаг байсан өмнөх жилүүдийн практик өөрчлөгдөх хандлагатай болж байгааг харуулж байна. Тухайлбал, өмнөх 2 жилийн байдлаар авч үзэхэд “Монгол даатгал” ХХК-ын даатгалын хураамжийн орлого 2005 оны нийт хураамжийн орлогод эзлэх хэмжээ 56 хувьтай байсан бол 2006 онд 40.8 хувь болж буурсан, харин “Миг даатгал” ХХК-ынх 21.9 хувь болж өссөн нь өмнөх жилүүдэд иргэний агаарын тээврийн хөлгийн даатгалын гэрээг “Монгол даатгал” компани хийж байсан бол 2006 онд “Миг даатгал” компани энэхүү гэрээг авсантай холбоотой байв. Энэ нь иргэний агаарын тээврийн хөлгийн даатгалын хураамж нь нийт хураамжийн орлогын дунджаар 25.5 хувийг эзэлж байдагтай холбоотой байсан бол энэ нөлөөлөл улам бүр багасч, даатгалын компаниуд нэг аж ахуйн нэгжтэй байгуулсан даатгалын томоохон гэрээний орлогоос аль болох бага хамааралтай болохын тулд өөрийн гэсэн тогтвортой олон жижиг даатгуулагчидтай болох бодлого барих болсонтой холбоотой юм. Ингэснээр даатгалын үйлчилгээний хамрах хүрээ өргөжиж, даатгалын шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүлэх боломж бүрдэж байна.

3. Нийт даатгалын хураамжийн 24 орчим хувийг “жолоочийн хариуцлагын даатгал” болон “автотээврийн хэрэгслийн даатгал”-ын хураамжийн орлого эзэлж байдаг бөгөөд эдгээр даатгалын хураамжийн 70 орчим хувийг зөвхөн 2 дугаар улиралд оруулж ирдэг нь тээврийн хэрэгслийн улсын үзлэг, тооллого энэ үеэр явагддагтай холбоотой. Энэ хэлбэрийн даатгалын хураамж 2 дугаар улиралд бөөн орж ирдэг бөгөөд бусад улиралд зөвхөн нөхөн төлбөр олгогдож, зарим улиралд ийм даатгалын үйл ажиллагаа алдагдалтай мэт харагддаг боловч тайлант оны эцэст нийт дүнгээрээ эерэг үзүүлэлттэй гардаг. Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын заавал даатгах даатгалын тухай хуулийн төсөл УИХ-аар хэлэлцэгдэж, батлагдсаны дараагаар 2009 оноос эхлэн тухайн даатгалын хэлбэрийн гэрээг жилийн туршид байгуулдаг болж, жолоочийн хариуцлагын даатгал алдагдалтай гэсэн ойлголтыг өөрчлөх боломжтой болно.

4. Даатгалын компаниуд 2006 онд даатгалын салбарын хэмжээгээр 4,776.5 сая төгрөгийн даатгалын болон үндсэн бус үйл ажиллагааны зардал гаргаж, 107.2 сая төгрөгийн татвар төлж, 129.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, үндсэн үйл ажиллагааныхаа зардлын 27.7 хувь буюу 1,144.0 сая төгрөгийг ажилтнуудын цалин хөлсөнд, 25.6 хувь буюу 1,058.5 сая төгрөгийг даатгалын төлөөлөгчдийн шимтгэлд тус тус зарцуулж байсан бол 2007 онд даатгалын компаниуд үндсэн үйл ажиллагааныхаа зардлын 25,3 хувь буюу 992,7 сая төгрөгийг цалин, нийгмийн даатгалд, 26,4 хувь буюу 1,035,3 сая төгрөгийг даатгалын төлөөлөгчдийн шимтгэлд тус тус зориулан зарцуулж, 3 даатгалын компани нийт 164.1 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Даатгалын компаниуд үндсэн үйл ажиллагааныхаа зардлын 25.6-26,4 хувийг даатгалын төлөөлөгчдөд шимтгэл болгон төлж байгаа нь даатгагчид даатгалын төлөөлөгчдөөр дамжуулан даатгуулагчидтай гэрээ хийх практик давамгайлсаар байгааг харуулж байна. Иймд Хорооноос даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгалын төлөөлөгчдөөр дамжуулан даатгалын гэрээ байгуулж байгаа эсэхэд тавих хяналтыг цаашид нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

5. Хорооны 2006 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын нөөцийн сан бүрдүүлэх, хуваарилах, хяналт тавих журам”-ыг мөн оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлэхээр заасан боловч тухайн үед нягтлан бодох бүртгэлийн дансны бичилт хийх болон санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, хэлбэрийн зааврууд батлагдаагүй байсан тул даатгалын учирч болзошгүй хохирлоос хамгаалах нөөцийн санг 1997 онд батлагдсан Даатгалын тухай хуулинд заасан хуучин аргаар даатгалын хураамжийн 60 хувиар тооцон байгуулж байсныг өөрчилж, 2007 оноос дээрх журмын дагуу 8-тын аргаар байгуулж эхэлсэн нь тодорхой үр дүнд хүрч байна. Шинэ журмаар даатгалын нөөцийн сан байгуулахад эхний улиралд нийт компанийн 60 хувь нь алдагдалтай ажиллаж байсан бол 2007 оны эцэст алдагдалтай компанийн тоо 3 болтлоо буурлаа. Энэ нь даатгалын нөөцийн санг 60 хувиар байгуулж байхад нийт даатгалын компанийн 50 хувь нь алдагдалтай ажиллаж байсан өмнөх практикт өөрчлөлт гарч, нөөцийн сан байгуулах 8-тын системийг нэвтрүүлснээр эерэг үр дүн гарч байгааг харуулж байна.

6. Цаашид даатгалын компаниудын санхүү, даатгалын үйл ажиллагааны талаарх мэдээллийг цаг алдалгүй шуурхай авдаг болж, зайнаас тавих хяналтыг нэмэгдүүлж, удирдлагын болон зохицуулалтын шуурхай байдлыг хангахад чигэлсэн даатгалын мэдээллийн нэгдсэн сан, программ хагамжийг нэвтрүүлэхэд хөрөнгө, хүчээ төвлөрүүлж ажиллах зорилт тавьж байна.